

# Санхүүгийн тайлан ба Хараат бус аудиторын тайлан

## Монголын хөрөнгийн бирж ТӨХК

2019 оны 12 дугаар сарын 31



# Агуулга

Хараат бус аудиторын дүгнэлт	3
Санхүүгийн байдлын тайлан	5
Орлогын дэлгэрэнгүй тайлан	6
Өмчийн өөрчлөлтийн тайлан	7
Мөнгөн гүйлгээний тайлан	8
Санхүүгийн тайлангийн тодруулгууд	9

**“ГРАНТ ТОРНТОН АУДИТ” ХХК**

Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний  
дэлхийн сүлжээний бие даасан фирм

# Хараат бус аудиторын дүгнэлт

Далай тауэр, 9 давхар,  
ЮНЕСКО гудамж - 31,  
Сүхбаатар дүүрэг,  
1 хороо Улаанбаатар  
14230, Монгол улс  
Т + 976 70 110744  
+ 976 70 110799

Dalai Tower, 9 floor,  
UNESCO street - 31,  
Sukhbaatar District-1,  
Ulaanbaatar 14230,  
Mongolia  
Т + 976 70 110744  
+ 976 70 110799

**“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:**

## *Дүгнэлт*

Бид “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК (цаашид “комлани” гэх)-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй, бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлан (цаашид “санхүүгийн тайлан” гэх)-д аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

## *Дүгнэлтийн үндэслэл*

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлага энэ тайлангийнхаа *Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага* гэсэн хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус Компаниас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлага бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, зохистой гэж итгэж байна.

## *Онцлох асуудал*

Санхүүгийн тайлангийн Тодруулга 2-д Тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой тодорхойгүй байдлыг тайлбарласан байгаад анхаарлаа хандуулна уу. Энэхүү асуудалтай холбоотойгоор бид дүгнэлтээ хязгаарлаагүй болно.

## *Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага*

Компанийн удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай байдаг.

Удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг

үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

### *Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага*

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайланг нь бүхэлдээ анги эсэх талаарх үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор буюу тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үл үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.



**Б.ОСОРГАРЭВ**  
**УДИРДАХ ПАРТНЕР**  
Монгол улс, Улаанбаатар хот  
2020 оны 3 сарын 31

# Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр		2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
	Тодруулга		
<b>Хөрөнгө</b>			
<i>Эргэлтийн хөрөнгө</i>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5	953,430	830,386
Дансны ба бусад авлага	6	58,360	316,406
Бараа материал	7	24,568	26,340
Бусад санхүүгийн хөрөнгө	8	1,000	1,000
Бусад эргэлтийн хөрөнгө	9	13,160	13,160
		<u>1,050,518</u>	<u>1,187,292</u>
<i>Эргэлтийн бус хөрөнгө</i>			
Үндсэн хөрөнгө	10	2,083,731	2,172,002
Биет бус хөрөнгө	11	653,006	1,192,669
		<u>2,736,737</u>	<u>3,364,671</u>
<b>Нийт хөрөнгө</b>		<u><u>3,787,255</u></u>	<u><u>4,551,963</u></u>
<b>Өр төлбөр болон эзэмшигчдийн өмч</b>			
<i>Эргэлтийн өр төлбөр</i>			
Дансны ба бусад өглөг	12	1,604,967	1,214,624
		<u>1,604,967</u>	<u>1,214,624</u>
<i>Капитал ба нөөц</i>			
Хувьцаат капитал	13	23,130,594	23,130,594
Эздийн өмчийн бусад хэсэг	14	446,322	446,322
Дахин үнэлгээний нөөц		12,362	12,362
Хуримтлагдсан алдагдал		(21,406,990)	(20,251,939)
		<u>2,182,288</u>	<u>3,337,339</u>
<b>Нийт өр төлбөр болон эзэмшигчдийн өмч</b>		<u><u>3,787,255</u></u>	<u><u>4,551,963</u></u>

Энэхүү санхүү байдлын тайланг тодруулгуудын хамт унших бөгөөд 9-өөс 28 дугаар хуудсан дах санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

# Орлогын дэлгэрэнгүй тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2019 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон	2018 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон
Орлого	15	1,474,669	1,656,960
Борлуулалтын өртөг		-	-
Нийт ашиг		1,474,669	1,656,960
Ерөнхий удирдлагын зардал	16	1,344,665	1,290,434
Миллениум Ай Ти системтэй холбоотой зардал	17	1,295,354	1,273,769
Үндсэн үйл ажиллагааны үр дүн		(1,165,350)	(907,243)
Санхүүгийн орлого	18	69,084	94,606
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз		1,150	-
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	19	(33,149)	(30,306)
Найдваргүй авлагын зардал	6	(25,338)	(18,171)
Бусад орлого		5,444	37,888
Миллениум Ай Ти системтэй холбоотой өмнөх жилийн зардал	17	-	(427,175)
Орлогын татварын өмнөх алдагдал		(1,148,159)	(1,250,401)
Орлогын татварын зардал	20	(6,892)	(9,444)
Тайлант жилийн алдагдал		(1,155,051)	(1,259,845)
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал		(1,155,051)	(1,259,845)

Энэхүү орлогын дэлгэрэнгүй тайланг тодруулгуудын хамт унших бөгөөд 9-өөс 28 дугаар хуудсан дах санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

# Өмчийн өөрчлөлтийн тайлан

Мянган төгрөгөөр			Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримт- лагдсан алдагдал	Нийт
	Хувьцаат капитал	Дахин үнэлгээний нөөц			
2018.01.01-ний байдлаар	21,884,000	12,362	1,692,916	(18,992,094)	4,597,184
Тайлант жилийн алдагдал	-	-	-	(1,259,845)	(1,259,845)
Хувьцаат капитал руу хөрвүүлэлт	1,246,594	-	(1,246,594)	-	-
2018.12.31-ний байдлаар	23,130,594	12,362	446,322	(20,251,939)	3,337,339
Тайлант жилийн алдагдал	-	-	-	(1,155,051)	(1,155,051)
2019.12.31-ний байдлаар	23,130,594	12,362	446,322	(21,406,990)	2,182,288

Энэхүү өмчийн өөрчлөлтийн тайланг тодруулгуудын хамт унших бөгөөд 9-өөс 28 дугаар хуудсан дах санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

# Мөнгөн гүйлгээний тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2019 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон	2018 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		<b>1,880,615</b>	<b>1,635,524</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		1,344,364	1,343,452
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		1,416	18,928
Бусад мөнгөн орлого		534,835	273,144
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>		<b>1,648,657</b>	<b>1,652,250</b>
Ажиллагчдад төлсөн		660,020	596,812
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		166,466	166,117
Бараа материал худалдан авахад төлсөн		40,977	48,930
Ашиглалтын зардалд төлсөн		89,714	71,407
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		10,166	8,248
Татварын байгууллагад төлсөн		280,384	184,983
Даатгалын төлбөрт төлсөн		-	547
Бусад мөнгөн зарлага		400,930	575,206
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>231,958</b>	<b>(16,726)</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		<b>167</b>	<b>167</b>
Хүлээн авсан хүүний орлого		167	167
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>		<b>109,081</b>	<b>459,939</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		16,093	37,266
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		92,988	422,673
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>(108,914)</b>	<b>(459,772)</b>
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		123,044	(476,498)
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>830,386</b>	<b>1,306,884</b>
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>953,430</b>	<b>830,386</b>

Энэхүү мөнгөн гүйлгээний тайланг тодруулгуудын хамт унших бөгөөд 9-өөс 28 дугаар хуудсан дах санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.



# Санхүүгийн тайлангийн тодруулгууд

## 1 Үйл ажиллагааны онцлог, ерөнхий мэдээлэл

Монгол Улсын Засгийн газрын 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 22 тоот тогтоолоор улсын өмч хувьчлалын ажлыг эхлүүлэх, цаашид үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх зорилгоор "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийг үүсгэн байгуулсан.

Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь үнэт цаасны арилжаа эрхлэх, брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий компанийг гишүүнээр элсүүлэх, гишүүнийг түдгэлзүүлэх, гишүүнээс хасах үйл ажиллагаа байна.

Компанийн өмчлөгч нь төр бөгөөд түүнийг төлөөлж хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг Сангийн яам хэрэгжүүлнэ.

## 2 СТОУС-ын хэрэглээ, тасралтгүй үйл ажиллагаа

### СТОУС-ын хэрэглээ

Эдгээр санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын зөвлөл ("НББОУСЗ")-өөс баталсан Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт ("СТОУС") ын дагуу бэлтгэв.

### Тасралтгүй үйл ажиллагаа

Компани нь тайлант хугацаанд 1,155,051 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан ба алдагдалтай ажиллахад Миллениум Ай Ти системийн ашиглалттай холбоотой зардал нөлөөлдөг байна. Богино хугацаат өр төлбөр нь эргэлтийн хөрөнгөөсөө илүү гарсан нь цаашид тасралтгүйгээр, үйл ажиллагаагаа хэвийн явуулахад нөлөөлөхөөр байна.

Компани нь алдагдлыг бууруулах зорилгоор 2020 онд борлуулалтын орлогыг 58%-иар нэмэгдүүлж 2,490,130 мянган төгрөг хүртэл, татварын өмнөх цэвэр алдагдлыг 39%-иар бууруулж, 451,885 мянган төгрөг байхаар төлөвлөж, Монгол улсын Засгийн газрын "ЭТТ-1072"-ийн талаар баримталж буй бодлоготой уялдуулан ажиллахаар болсон байна.

Мөн Сангийн яамны зүгээс 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК болон "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-иудыг системийн ашиглалтын зардлыг Миллениум Ай Ти системийн "CSD" модульд ногдох үнээр хувь тэнцүүлэн, харилцан тохиролцож, хамтарч ажиллах чиглэлийг өгсөн боловч талууд өнөөг хүртэл тодорхой шийдэлд хүрч чадаагүй байна.

2019 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн тайлангууд түүний тодруулгуудыг 2020 оны 3 дугаар 31-ний өдөр компанийн удирдлага баталсан. (Тодруулга 29-г харна уу).

## 3 Шинэ болон өөрчлөлт орсон стандартууд болон хэрэглээний тайлбарууд

### 3.1 2019 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжүүлж эхэлсэн шинэ стандартууд

Компани нь тайлант оноос СТОУС-н шаардлагын дагуу дараах шинэчлэгдсэн болон шинээр гарсан стандартуудыг мөрдөж эхлэсэн. Үүнд:

СТОУС 16 Түрээс нь НББОУС 17 Түрээс, болон түүний дагалдах гурван тайлбаруудыг орлоно (СТОУТХ 4 – Хэлцэлд түрээс агуулагдаж байгаа эсэхийг тодорхойлох, БТХ 15 Үйл ажиллагааны түрээс – Урамшуулал, БТХ 27 Түрээсийн хууль ёсны хэлбэрийг агуулсан ажил гүйлгээний шинж чанарыг үнэлэх).

Шинэ стандартыг мөрдөж эхлэснээр бага дүнтэй эсвэл 12 сараас доош хугацааг хамрах үйл ажиллагааны түрээсээс бусад үйл ажиллагааны түрээсийг ашиглах эрхийн хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх ба түүнд хамаарах ер төлбөрийг мөн хүлээн зөвшөөрч бүртгэх болсон.

СТОУС 16-г өмнөх үе рүү буцаан мөрдөх ба хуримтлагдсан нөлөөллийг тайлант оны хуримтлагдсан ашгийн эхний үлдэгдэлд тохируулан харуулна. Түрүү онуудын санхүүгийн тайланг залруулахгүй. Стандартыг мөрдөж эхлэх үед хэрэгжиж байсан гэрээний тухайд НББОУС 17 болон СТОУТХ 4-д заасан түрээсийн тодорхойлолтыг ашиглах нөхцөлийг сонгосон ба НББОУС 17 болон СТОУТХ 4-ийн дагуу түрээсийн тодорхойлолтод нийцээгүй гэрээг СТОУС 16-аар дахин ангилахгүй.

Компани нь 2019 оны 1 дүгээр сарын 1-нээр тус стандартыг мөрдөж эхлэх үед оршин байсан ашиглах эрхийн хөрөнгөөр дахин ангилагдсан үйл ажиллагааны түрээсэд хамаарах анхны шууд өртгийг хөрөнгийн хэмжилтэд хамааруулахгүй байхаар бүртгэлийн бодлогодоо тусгасан. Шинэ стандартыг мөрдөж эхэлсэн өдрөөр ашиглах эрхийн хөрөнгийг хэмжихдээ тус өдрөөр үүссэн түрээсийн урьдчилгаа болон хуримтлагдсан төлбөрүүдийн нийлбэрээр түрээсийн ер төлбөр үүсгэж бүртгэнэ.

СТОУС 16-г анхлан мөрдөж эхлэх өдрөөс өмнө тухайн ашиглах эрхийн түрээс нь алдагдалтай гэрээ болох эсэхийг түүхэн үнэлгээний аргаар тодорхойлох ба хорогдуулалтын аргыг анхны хэмжилтэд ашиглахгүй.

Тус шилжилтийн үед өмнө нь үйл ажиллагааны түрээсээр бүртгэгдэж байсан бага дүнтэй болон тухайн өдрөөс хойш 12 сараас бага хугацааг хамрах түрээсүүдийг ашиглах эрхийн хөрөнгө гэж ангилахгүй ба үлдсэн гэрээний хугацаанд түрээсийн төлбөрийг шулуун шугамын аргаар зардлаар бүртгэнэ.

Санхүүгийн түрээсийн ангилалд бүртгэлтэй байсан түрээсүүдийн хувьд ашиглах эрхийн хөрөнгө болон түрээсийн ер төлбөрийг СТОУС 16-н дагуу анхлан хэмжихдээ НББОУС 17-ийн дагуу тооцоологдсон дүнгээр хүлээн зөвшөөрнө.

### **3.2 Хүчин төгөлдөр болоогүй буюу хэрэглэж эхлээгүй стандартууд, стандартын нэмэлт өөрчлөлт болон тайлбарууд**

Санхүүгийн тайланг батласан өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөх хугацаа болоогүй НББОУС3-ийн өөрчлөлт оруулсан стандарт болон түүний тайлбарууд байгаа ба Компани нь тэдгээр стандарт болон өөрчлөлтийг урьдчилан мөрдөж эхлээгүй байгаа юм.

Компанийн удирдлага тухайн өөрчлөлтүүдийг хүчин төгөлдөр болох өдөр эсвэл түүний дараагаар мөрдөж эхлэхээр төлөвлөж байна. Тайлант онд дагаж мөрдөх шаардлагагүй тухайн өөрчлөлтүүдийг тодруулгаар үзүүлээгүй ба тэдгээр нь санхүүгийн тайланд материаллаг нөлөөлөл үзүүлэхгүй.

## **4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд**

### **4.1 Бүртгэлийн суурь**

Эдгээр санхүүгийн тайланг аккруэль сууриар бэлтгэсэн ба үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ, хөрөнгө оруулалт болон тодорхой санхүүгийн хэрэглүүрүүдээс бусад зүйлсийг түүхэн өртгийн сууриар бэлтгэсэн.

### **4.2 Гадаад валют хөрвүүлэлт**

#### **Үйл ажиллагааны болон толилуулгын валют**

Санхүүгийн тайлангуудыг Монгол төгрөгөөр толилуулсан.

#### **Гадаад валютаарх ажил гүйлгээ болон үлдэгдэл**

Гадаад валютаар илэрхийлэгдсэн ажил гүйлгээг Компанийн үйл ажиллагааны валют руу тухайн өдрийн ханш ашиглан хөрвүүлнэ. Ажил гүйлгээнээс үүссэн валютын ханшийн олз гарз болон гадаад валютаарх дансдын үлдэгдлийг жилийн эцсийн валютын ханшаар хөрвүүлсэнтэй холбоотой олз гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Зах зээлийн үнээр хэмжигддэгээс бусад мөнгөн бус зүйлсийг ажил гүйлгээ хийгдсэн өдрийн түүхэн ханшаар бүртгэж, тайлант жилийн эцэст тэгшитгэл хийхгүй.

### 4.3 Орлого хүлээн зөвшөөрөлт

Орлого хүлээн зөвшөөрөхдөө Компани нь дараах 5-н алхамыг мөрддөг. Үүнд:

1. Үйлчлүүлэгчтэй байгуулсан гэрээг тодорхойлох
2. Гэрээний үүрэг хариуцлагын биелэлтийг тодорхойлох
3. Арилжааны үнийг тодорхойлох
4. Арилжааны үнийг гэрээний гүйцэтгэх үүргүүдэд хувиарлах
5. Аж ахуйн нэгж гүйцэтгэх үүргээ биелүүлсэн үедээ орлогыг хүлээн зөвшөөрөх

Компани нь бараа, ажил үйлчилгээтэйгээ холбоотойгоор олон төрлийн ажил гүйлгээ хийдэг. Иймд гэрээний нийт үнийн дүн нь үүрэг хариуцлагын төрөл бүрт тус тусын үнийн дүнд харгалзуулан хуваарилагддаг. Гэрээний үнийн дүнд гуравдагч этгээдэд олгох төлбөрийг хамруулахгүй.

Орлогыг тохиролцсон барааг шилжүүлсэн болон ажил үйлчилгээг үзүүлэх гэрээний үүргээ биелүүлсэн бол тухайн мөчид эсвэл тодорхой хугацааны явцад хүлээн зөвшөөрнө.

Хэрэгжээгүй үүрэгт хамаарах орлого орох үед гэрээний өр төлбөрөөр хүлээн зөвшөөрөх ба санхүүгийн байдлын тайланд бусад өр төлбөрөөр харуулна. Үүнтэй адилаар төлбөр ирэхээс өмнө тохиролцсон үүргийг биелүүлэх үед гэрээний хөрөнгө эсвэл авлагаар санхүүгийн байдлын тайланд тусгана.

### 4.4 Үйл ажиллагааны зардал

Үйл ажиллагааны зардал нь ажил үйлчилгээ гарсан үед ашиг алдагдалд хүлээн зөвшөөрөгдөнө. Борлуулсан бараа үйлчилгээний баталгаатай холбоотой зардлыг Компани нь үүргээ биелүүлсэн үед буюу ихэнх тохиолдолд холбогдох бараа ажил үйлчилгээ борлуулагдсан үед хүлээн зөвшөөрдөг.

### 4.5 Бусад биет бус хөрөнгө

#### Бусад биет бус хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлт

##### Дотооддоо хөгжүүлсэн програм хангамж

Мэдээлэл технологийн, харилцаа холбооны системийн зорилгоор шинээр хөгжүүлж буй програм хангамжийн судалгааны зардлыг гарсан үед нь зардлаар хүлээн зөвшөөрнө.

Хөгжүүлэлтийн үе шатанд гарсан зардлыг дараах шаардлагыг хангаж байгаа тохиолдолд биет бус хөрөнгөд хуримтлуулан бүртгэнэ. Үүнд:

- Хөгжүүлэлтийн зардлыг бодитоор хэмжиж болох
- Төслийн техникийн болон арилжааны үр дүн амжилттай болох нь тодорхой
- Компани нь тухайн төслийг хэрэгжүүлж дуусгахад шаардлагатай хангалттай нөөцтэй
- Тухайн програмыг ашиглах эсвэл борлуулах боломжтой
- Тухайн програмаас ирээдүйн эдийн засгийн өгөөж ирэх нь тодорхой

Дээрх капиталжуулалтын шаардлагыг хангаагүй зардлууд нь зардлаар хүлээн зөвшөөрөгдөнө.

Холбогдох зардлуудад програм хөгжүүлэхтэй холбоотой гарсан ажилчдын зардал болон нэмэгдэл зардлууд нь хөгжүүлэлтэд хамаарах хэмжээгээр хуваарилагдана.

##### Дараа үеийн хэмжилт

Ашиглах хугацаа нь тодорхой дотооддоо хөгжүүлэн капиталжуулсан програм зэрэг биет бус хөрөнгүүдийг өртгийн аргаар бүртгэх ба ашиглах хугацааны туршид шулуун шугамын аргаар

хорогдуулна. Үлдэх өртөг болон ашиглах хугацааг тайлант жил бүр дахин тооцно. Мөн үнэ цэнийн бууралтын тест хийнэ.

Капиталжуулж буй хөгжүүлэлт нь дуусаагүй програм хангамжийг хорогдуулахгүй боловч үнэ цэнэ бууралтын тест хийнэ.

Хорогдуулсан зардал нь санхүүгийн бус хөрөнгийн элэгдэл, хорогдол, үнэ цэнэ бууралтын дансанд бүртгэгдэнэ.

Програм хангамж болон бренд нэртэй холбоотой дараа үед гарах засварын зардлыг зардлаар хүлээн зөвшөөрнө.

Биет бус хөрөнгийг борлуулсанаас үүсэх олз гарзыг борлуулалтын үнэ болон дансны үнийн зөрүүгээр хүлээн зөвшөөрч, бусад орлого болон зардлын дансанд ашиг болон алдагдлаар бүртгэнэ.

#### 4.6 Үндсэн хөрөнгө

##### **Барилга, компьютер дагалдах хэрэгсэл болон бусад тоног төхөөрөмж**

Тавилга эд хогшлыг хамруулан барилга, компьютер дагалдах хэрэгсэл болон бусад тоног төхөөрөмжийг хөрөнгийг ашиглалтын байршилд авч ирэхэд гарсан зардлууд болон тухайн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглахад шаардлагатай гарсан зардлуудыг хамруулан худалдан авсан өртөг эсвэл үйлдвэрлэлийн өртгөөр анхлан бүртгэнэ. Санхүүгийн түрээсийн хөрөнгүүд нь барилга болон компьютер дагалдах хэрэгслийн адил бүртгэгдэнэ. Ажил үйлчилгээний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн зорилгоор ашиглаж буй [Үндсэн хөрөнгийн ангиллыг газар, барилга гэх мэтээр тайлбарла] зэрэг хөрөнгүүдийг санхүүгийн тайланд дахин үнэлсэн дүн буюу дахин үнэлгээ хийсэн өдрөөрх дүнгээс дараа үеийн хуримтлагдсан элэгдсэн болон дараа үеийн үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр тайлагнана.

Элэгдлийг хөрөнгө тус бүрийн ашиглах хугацаагаар шулуун шугамын аргаар тооцож, ашиг алдагдлаар тусгана. Хөрөнгийг ашиглах боломжтой болсон үед элэгдүүлж эхлэнэ. Хөрөнгийн ашиглах хугацааг дараах байдлаар тогтооно.

Байшин барилга	60 жил
Автомашин	6 жил
Тавилга, эд хогшил	5-10 жил
Тоног төхөөрөмж	3-10 жил

Ашиглах эрхийн хөрөнгийн ашиглах хугацааг тодорхойлохдоо гэрээний нөхцөл эсвэл өмчлөлд байгаа ижил төстэй хөрөнгийн ашиглах хугацааны аль багаар тогтооно. Материаллаг дүнтэй үлдэх өртөг тооцоолол болон хөрөнгийн ашиглах хугацааны тооцооллыг багадаа жилд нэг удаа шинэчлэнэ.

Үндсэн хөрөнгийн данснаас хассан, ашиглалтаас гаргаснаас үүссэн олз, гарзыг тухайн хөрөнгийн борлуулалт болон дансны үнийн зөрүүгээр тодорхойлох ба олз, гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

#### 4.7 Биет бус хөрөнгө болон үндсэн хөрөнгийн үнэ цэнэ бууралтын тест

Хөрөнгүүдийг үнэ цэнийн бууралтын зорилгоор тусдаа мөнгөний урсгалд (мөнгөн бий болгогч нэгж)-д суурилан боломжит хамгийн жижиг бүлгүүдэд хуваадаг. Үүний үр дүнд зарим хөрөнгийн үнэ цэнийн бууралт дангаараа хийгддэг бол зарим хөрөнгүүд мөнгө бий болгогч нэгжийн түвшинд үнэлэгддэг.

Үнэ цэнийн бууралтын алдагдлыг хөрөнгийн нөхөгдөх дүнгээс давсан дансны үнийн дүнгээр хүлээн зөвшөөрнө. Нөхөгдөх дүн нь ашиглалтын үнэ цэнэ болон бодит үнэ цэнээс борлуулалтын өртгийг хассан дүнгийн аль өндрөөр тодорхойлогдоно. Ашиглалтын үнэ цэнийг тодорхойлохдоо удирдлага нь мөнгө бий болгогч нэгж бүрийн ирээдүйн мөнгөн урсгалыг тооцох ба тухайн мөнгөн урсгалын

өнөөгийн үнэ цэнийг тооцохын тулд зохих дискаунтын түвшинг тодорхойлдог. Үнэ цэнийн бууралтын төстэд ашигласан мэдээлэл нь ирээдүйд гарах зохион байгуулалтын өөрчлөлт, хөрөнгийн сайжруулалтын үр нөлөөг хамруулаагүй Компанийн хамгийн сүүлд батлагдсан төсөвт үндэслэдэг. Мөнгө бий болгогч нэгж бүрт дискаунтын хүчин зүйлсийг тодорхойлох бөгөөд мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ болон хөрөнгийн тусгайлсан эрсдэлийн хүчин зүйлсийг тусгасан зах зээлийн үнэлгээнд суурилдаг.

Мөнгө бий болгогч нэгжид үнэ цэнэ бууралтын гарзыг хуваарилахдаа тухайн нэгжид хамаарах гүүдвиллийн үлдэгдлийг хамгийн эхэнд бууруулна. Үлдсэн гарзыг нь мөнгө бий болгогч нэгжид хамаарах хөрөнгүүдэд тэнцүүлсэн хэмжээгээр хуваарилна.

Гүүдвилээс бусад хөрөнгийн өмнө нь хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдал цаашид байхгүй болох шинж тэмдэг илэрсэн эсэхийг үнэлдэг. Хөрөнгийн болон бэлэн мөнгө үүсгэх нэгжийн нөхөгдөх үнэ нь түүний дансны үнээс давсан тохиолдолд үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаана.

## 4.8 Санхүүгийн хэрэглүүр

### *Хүлээн зөвшөөрөлт ба үл хүлээн зөвшөөрөлт*

Компани нь тухайн санхүүгийн хэрэглүүрд хамаарах гэрээний оролцогч тал болсон үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгөөс бий болох мөнгөний урсгал дах гэрээний эрх дуусгавар болоход эсвэл санхүүгийн хөрөнгөд хамаарах бүх бодит эрсдэл, өгөөж шилжихэд санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

### *Санхүүгийн хөрөнгийн ангилал ба анхдагч хэмжилт*

Санхүүгийн хувьд чухал бүрэлдэхүүн хэсэг агуулаагүй дансны авлага болон СТОУС 15-ын дагуу ажил гүйлгээний үнээр бүртгэгддэгээс бусад бүх санхүүгийн хөрөнгийг ажил гүйлгээний зардлыг тохируулсан бодит үнэ цэнээр хэмжинэ.

Хейджийн хэрэглүүрээс бусад санхүүгийн хөрөнгийг дараах байдлаар ангилна. Үүнд:

- Хорогдуулсан өртөг
- Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх санхүүгийн хөрөнгө (БҮЦБДО)
- Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг алдагдалд бүртгэх санхүүгийн хөрөнгө (БҮЦАА)

Тайлант онд компанид БҮЦБДО-оор ангилагдах санхүүгийн хөрөнгө байхгүй байна.

Ангиллыг тодорхойлохдоо:

- Санхүүгийн хөрөнгийг зохицуулах бизнесийн загвар
- Санхүүгийн хөрөнгийн гэрээлсэн мөнгөн урсгалын шинж чанарыг тус тус харгалзан үзнэ.

Санхүүгийн хөрөнгөтэй холбоотой бүх орлого болон зардал нь санхүүгийн зардал, санхүүгийн олз болон бусад санхүүгийн зүйлсээр орлого болон зардалд хүлээн зөвшөөрөгдөх ба харин дансны авлагын үнэ цэнийн бууралт нь бусад зардлаар хүлээн зөвшөөрөгдөнө.

### *Санхүүгийн хөрөнгийн дараа үеийн хэмжилт*

Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгө

Дараах хоёр нөхцөл биелсэн тохиолдолд санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр хэмжинэ (БҮЦАА-аар ангилагдаагүй үед):

- Тухайн санхүүгийн хөрөнгийг гэрээний мөнгөн урсгал "цуглуулах зорилгоор санхүүгийн хөрөнгө эзэмшдэг" бизнесийн загварын хүрээнд эзэмшиж байгаа бол, мөн
- Тухайн санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгал нь "зөвхөн үндсэн ба хүүгийн төлбөр" (SPPI) байвал.

Санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрсний дараа хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтын хасагдууллыг хассан дүнгээр хэмжинэ. Хүүг үр ашигт хүүгийн аргаар тооцоолно. Анхны үнэ цэнийн бууралтын хасагдуулга болон дараа үеийн өөрчлөлтүүдийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

### **Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд бүртгэх санхүүгийн хөрөнгө (БҮЦАА)**

Хорогдуулсан өртгөөр хэмжих эсвэл бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх ангиллын шаардлагад нийцэхгүй санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд бүртгэнэ.

Мөн тодорхой тохиолдолд санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд бүртгэхээр тогтож болно. Тухайлбал банк дараа үед хорогдуулсан өртгөөр хэмжих эсвэл бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд бүртгэх сонголт хийж болно. Ийм сонголтыг зөвхөн нягтлан бодох бүртгэлийн зөрүүтэй байдлыг арилгах эсвэл ихээхэн хэмжээгээр бууруулж байгаа тохиолдолд хийнэ.

Дээрх сонголтыг бүх ижил төстэй ажил гүйлгээнд мөрдөх шаардагатай. Харин энэ нь илүү мэдээлэл бий болгож байгаа тохиолдолд банк сонгож болох хувилбар юм.

### **Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх санхүүгийн хөрөнгө (БҮЦБДО)**

Дараах хоёр нөхцөл биелсэн тохиолдолд санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлнэ:

- Тухайн санхүүгийн хөрөнгийг гэрээний мөнгөн урсгал "цуглуулах ба борлуулах зорилгоор санхүүгийн хөрөнгө эзэмшдэг" бизнесийн загварын хүрээнд эзэмшиж байгаа бол, мөн
- Тухайн санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгал нь "зөвхөн үндсэн ба хүүгийн төлбөр" (SPPI) байвал.

Хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх үед бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөгдсөн олз, гарзыг ашиг, алдагдалд дахин ангилна.

#### **Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт**

СТОУС 9-ийн дагуу хүлээгдэж буй алдагдлын үнэ цэнийн бууралтыг тооцоходоо илүү ирээдүйд чиглэсэн мэдээлэлд суурилах болсон ба үүнийг хүлээгдэж буй алдагдлын аргачлал гэж нэрлэдэг. Энэ нь НББОУС 39-ийн алдагдлыг бодитоор бий болсон үед хүлээн зөвшөөрөх аргыг орлох болсон.

Энэхүү шинэ шаардлагын дагуу хорогдсон өртгөөр болон БҮЦБДО-оор хэмжигдэх өрийн төрлийн санхүүгийн хөрөнгүүд, дансны авлага, СТОУС 15-ын дагуу хүлээн зөвшөөрөгдөн, хэмжигдсэн гэрээний хөрөнгө болон БҮЦАА-аар хэмжигддэггүй зарим санхүүгийн баталгааны гэрээг хамруулна.

Алдагдлыг хүлээн зөвшөөрөхөд Компани нь алдагдал үүсэх нөхцөл бий болохыг хүлээх шаардлагагүй болсон. Харин Компани нь эрсдэлийг үнэлэх болон хүлээгдэж буй алдагдлыг хэмжихдээ өнгөрсөн үйл явдлууд, одоогийн нөхцөл байдал, хэрэгслийн ирээдүйн мөнгөн урсгалын хүлээгдэж буй цуглуулгад нөлөөлөх үндэслэлтэй дэмжигдэхүйц тамааглал зэрэг мэдээллийг харгалзан үздэг.

Тус аргачлалыг ашиглахад дараах зүйлсийг ялгаж харах шаардлагатай. Үүнд:

- Тухайн санхүүгийн хөрөнгийг хүлээн зөвшөөрснөөс хойш түүний эрсдэл их хэмжээгээр нэмэгдээгүй, тайлант хугацааны үеэр бага эрсдэлтэй байгаа бол (Шатлал 1)
- Анхны хүлээн зөвшөөрөлтөө хойш чанар мэдэгдэхүйц муудсан, эрсдэл бага биш байгаа санхүүгийн хэрэгслүүд (Шатлал 2)

Шатлал 3 нь тайлагналын өдөр үнэ цэнэ бууралтын бодит нотолгоо олдсон санхүүгийн хөрөнгүүдийг хамруулна.

Дараагийн 12 сард хүлээгдэж буй алдагдлыг Шатлал 1-д, нийт хугацаанд хүлээгдэж буй алдагдлыг Шатлал 2-д хүлээн зөвшөөрнө.

Хүлээгдэж буй алдагдлыг хэмжихдээ санхүүгийн хэрэгслийн хүлээгдэж буй хугацаанд алдагдлын магадлалын жингийн тооцооллоор тодорхойлно.

### **Дансны болон бусад авлага, гэрээний хөрөнгө**

Компани нь дансны болон бусад авлагын авлага, гэрээний хөрөнгийг хялбаршуулсан аргаар нягтлан бодох бүртгэлд тусгадаг бөгөөд алдагдлын нөөцийг хүлээгдэж буй алдагдлын аргаар бүртгэдэг. Эдгээр нь санхүүгийн хэрэгслийн ашиглалтын хугацааны аль ч үед дефолт болох магадлалыг харгалзан үзсэн гэрээний мөнгөн урсгалын хүлээгдэж буй дутагдал юм. Нөөцийн матрицийг ашиглан хүлээгдэж буй алдагдлыг тооцоолохдоо Компани нь өөрийн түүхэн туршлага, гадаад хүчин зүйлс, ирээдүйд чиглэсэн мэдээллийг ашигладаг.

Компани нь дансны авлагын үнэ цэнийн бууралтыг тооцохдоо хугацаа хэтэрсэн өдрүүдээр нь бүлэглэн эрсдлийн шинж чанарт ангилан үнэлнэ. СТОУС 9-ийн үнэ цэнийн бууралтын шаардлагыг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар нарийвчилсан шинжилгээг тодруулга ...-с үзнэ үү.

### **Санхүүгийн өр төлбөрийн ангилал болон хэмжилт**

Компанийн санхүүгийн өр төлбөрт, дансны болон бусад өглөг, үүсмэл санхүүгийн хэрэгслүүд орно.

Санхүүгийн өр төлбөрийг БУЦАА-с өөрөөр хэмжих үед ажил гүйлгээний үнэ цэнийг тохируулсан бодит үнэ цэнээр нь хэмждэг.

Дараа үед санхүүгийн өр төлбөрийг БУЦАА-р тодорхойлсон санхүүгийн өр төлбөр болон деривативаас бусад тохиолдолд үр ашигт хүүгийн арга ашиглан хорогдсон өртгөөр хэмжинэ. Бодит үнэ цэнийн олз гарз нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Бүх хүүтэй холбоотой зардал болон санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг санхүүгийн зардал эсвэл санхүүгийн орлогоор ашиг алдалд хүлээн зөвшөөрнө.

## **4.9 Бараа материал**

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар тайлагнана. Бараа материалын өртөг жинлэсэн дундажийн зарчимд суурилдаг ба бараа материалын худалдан авалтын зардал болон одоогийн байршил, нөхцөлд авчрахтай холбоотой гарсан бүх зардал багтана. Цэвэр боломжит үнэ цэнийг бизнесийн хэвийн ажиллагааны үеийн бараа материалын борлуулах үнээс бараа материалыг иж бүрдэл болгох зардал ба борлуулах зардлыг хасч тооцно

## **4.10 Орлогын албан татвар**

Ашиг алдагдалд хүлээн зөвшөөрөгдсөн татварын зардал нь хойшлогдсон татвар болон бусад дэлгэрэнгүй орлогод эсвэл өмчид хүлээн зөвшөөрөгдөөгүй тайлант үеийн татварын нийлбэрээр тодорхойлогдоно.

Тайлант үеийн татварын тооцоолол нь тайлант оны эцсээр хүчинтэй болсон эсвэл хүчин төгөлдөр мөрдөгдөж буй татварын хувь хэмжээнд суурилна. Хойшлогдсон орлогын албан татварыг балансын өр төлбөрийн аргыг ашиглан тооцно.

Хойшлогдсон татварын хөрөнгийг татварын алдагдал болон түр хасагдах зөрүүг ашиглаж болохуйц хэмжээний татвар ногдох ашиг олох магадлалтай байгаа үед хүлээн зөвшөөрнө. Энэ нь Компанийн ирээдүйн үйл ажиллагааны үр дүнгийн таамаглал, татвар ногдуулахгүй орлого, зардлын тохируулга, ашиглагдаагүй татварын алдагдал эсвэл өгөөжийн ашиглагдах боломжийн хязгаарлалтыг үндэслэн үнэлэгддэг.

Хойшлогдсон татварын өр төлбөрийг ерөнхийдөө бүх татвар ногдох түр зөрүүнд хүлээн зөвшөөрөх боловч НББОУС 12 Орлогын албан татвар-ын дагуу зарим хязгаарлалтыг харгалзан үзнэ. Тус хязгаарлалттай холбоотойгоор гүүдвил болон охин компани дах хөрөнгө оруулалтад хойшлогдсон татварын түр зөрүү хүлээн зөвшөөрдөггүй.

## **4.11 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө**

Мөнгөн гүйлгээний тайлан бэлтгэх зорилгоор Мөнгөтэй адилтгах хөрөнгөд үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг, хөрвөх чадвар сайтай богино хугацааны хөрөнгө оруулалт, бэлэн мөнгө, хадгаламж зэргийг хамруулдаг.

#### 4.12 Өмч, нөөц, ногдол ашгийн төлбөр

Хувьцаат капитал нь гаргасан хувьцааны нэрлэсэн үнийг илэрхийлнэ.

Хуримтлагдсан алдагалд тайлант болон өмнөх хугацааны бүх ашиг багтана.

#### 4.13 Ажилчдын богино хугацааны тэтгэмж

##### **Богино хугацааны ажилчдын тэтгэмж**

Ажилчдад олгох богино хугацааны тэтгэмж ажилчид холбогдох үйлчилгээ үзүүлсэн жилийн тайлант хугацааны эцсээс хойш 12 сарын дотор олгох тэтгэмж бөгөөд дараахийг багтаана. Үүнд:

- (a) цалин урамшуулал;
- (b) ээлжийн амралтын мөнгө, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж;

Ажилчид Компанид тайлант жилд үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд Компани уг үйлчилгээний төлбөрт төлөх ажилчдын богино хугацааны тэтгэмжийн дискаунтлаагүй дүнг хүлээн зөвшөөрдөг. Ингэхдээ:

- (a) аль хэдийнэ төлсөн дүнг хассаны дараа өр төлбөрөөр (хуримтлагдсан зардал). Аль хэдийнэ төлсөн дүн тэтгэмжийн дискаунтлаагүй дүнгээс давсан бол Компаниуг давсан дүнг урьдчилгаа төлбөр нь ирээдүйд хийх төлбөрийг бууруулна эсвэл буцаалт авна гэсэн утгаар хөрөнгөөр (урьдчилж төлсөн зардал) хүлээн зөвшөөрнө.
- (b) уг дүн нь хөрөнгийн өртөгт ороогүй бол зардлаар.

##### **Цалинтай чөлөө**

Цалинтай чөлөө хэлбэрээр олгох ажилчдын богино хугацааны тэтгэмжийн хүлээгдсэн өртгийг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

- (a) ажилчдын үзүүлж буй үйлчилгээ ирээдүйд цалинтай чөлөө авах эрхийг нэмэгдүүлж байгаа үед хуримтлуулсан цалинтай чөлөөгөөр.
- (b) Чөлөө авах үед хуримтлуулаагүй цалинтай чөлөөгөөр.

##### **Урамшуулал**

Компани зөвхөн өнгөрсөн үйл явдлын үр дүнд мөн үүрэг хариуцлагын найдвартай тооцоолол хийх боломжтой тохиолдолд тийм төлбөр хийх өнөөгийн хууль ёсны болон үүсмэл үүрэг хүлээсэн бол урамшууллын төлбөрийн хүлээгдсэн өртгийг хүлээн зөвшөөрнө.

Өнөөгийн үүрэг хариуцлага зөвхөн тухайн аж ахуйн нэгжид төлбөр хийхээс өөр бодитой хувилбар байхгүй тохиолдолд л оршино.

#### 4.14 Нягтлан бодох бүртгэлийн бодлого болон тооцооллын тодорхойгүй байдалд удирдлагын шүүн тунгаалтыг ашиглах нь

Компанийн удирдлага санхүүгийн тайлан бэлтгэхдээ хөрөнгө, өр төлбөр, орлого болон зардал хүлээн зөвшөөрөхтэй холбоотой шүүн тунгаалт, тооцоолол, таамаглал ашигладаг.

##### **Удирдлагын томоохон тооцоолол, таамаглал**

Компани нь нягтлан бодох бүртгэлийн бодлогоо баримтлахад үүсдэг санхүүгийн тайланд томоохон нөлөөлөл үзүүлэхүйц удирдлагын тооцоолол, таамаглалыг доор харуулав. Үүнд:

##### **Хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрөлт**

Хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрөхдөө шилжүүлсэн татварын алданги болон хасагдах түр зөрүү нь ирээдүйн татвар ногдох орлогоор нөхөгдөх магадлалын үнэлгээнд үндэслэнэ. Мөн татварын орчин дахь хууль эрх зүйн болон эдийн засгийн хязгаарлалт, тодорхойгүй байдлын нөлөөллийг үнэлж дүгнэдэг.



## 5 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Бэлэн мөнгө	1,808	2,347
Банкны үлдэгдэл (төгрөг)	852,261	827,782
Банкны үлдэгдэл (гадаад валют)	99,361	257
	<u>953,430</u>	<u>830,386</u>

## 6 Дансны ба бусад авлага

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Дансны авлага	316,972	546,058
Ажилчдаас авах авлага	4,270	4,556
Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага	368	-
	<u>321,610</u>	<u>550,614</u>
Найдваргүй дансны авлагын хасагдуулга	(271,591)	(251,153)
Цэвэр дансны авлага	<u>50,019</u>	<u>299,461</u>
Урьдчилгаа, урьдчилж төлсөн тооцоо	8,341	16,945
	<u>58,360</u>	<u>316,406</u>

Дансны авлагын цэвэр дансны үнэ нь бодит үнэтэй ойролцоо гэж үзэж байна.

Дансны авлагад хүү тооцохгүй

Эдгээр авлагын насжилтын шинжилгээг дор харуулав:

2019 оны 12 сарын 31-ний байдлаар	Дансны авлагын хугацаа хэтрэлт				Нийт
	Хэвийн	30 өдрөөс дээш	60 өдрөөс дээш	90 өдрөөс дээш	
Нийт дансны үнэ	6,925	-	-	314,317	321,242
	<u>6,925</u>	<u>-</u>	<u>-</u>	<u>314,317</u>	<u>321,242</u>

2018 оны 12 сарын 31-ний байдлаар	Дансны авлагын хугацаа хэтрэлт				Нийт
	Хэвийн	30 өдрөөс дээш	60 өдрөөс дээш	90 өдрөөс дээш	
Нийт дансны үнэ	236,194	-	-	314,420	550,614
	<u>236,194</u>	<u>-</u>	<u>-</u>	<u>314,420</u>	<u>550,614</u>

Найдваргүй авлагын нөөцийн хөдөлгөөнийг дор харуулав:

Мянган төгрөгөөр	2019	2018
Эхний үлдэгдэл	251,153	259,907
Нөөцийн залруулга	(4,900)	(26,925)
Тайлант хугацааны нөөцийн өсөлт	25,338	18,171
	<u>271,591</u>	<u>251,153</u>

Авлага барагдуулалтыг тооцохдоо Компани нь зээл олгосон өдрөөс тайлант өдөр хүртэлх эргэн төлөлтийн өөрчлөлтийг авч үздэг байна.

Авлага болон бусад авлага гадаад валютаар илэрхийлсэн тааларх нягтлан бодох бүртгэлийн бодлогыг Тодруулга 4.2-оос харна уу.

## 7 Бараа материал

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	15,644	10,213
Хангамжийн материал	7,905	6,650
Сэлбэг хэрэгсэл	1,019	9,477
	<u>24,568</u>	<u>26,340</u>

## 8 Бусад санхүүгийн хөрөнгө

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Засгийн газрын бонд	1,000	1,000
	<u>1,000</u>	<u>1,000</u>

## 9 Бусад эргэлтийн хөрөнгө

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Борлуулах зорилготой хөрөнгө	13,160	13,160
	<u>13,160</u>	<u>13,160</u>

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн суманд байрлах Компанийн эзэмшлийн 304 га газрыг 2010 оны 10 дугаар сарын 13-ны өдөр худалдан борлуулахаар "Бүрэн эрдэнэ монс" ХХК-тай тохиролцсон байна.

## 10 Үндсэн хөрөнгө

Мянган төгрөгөөр	Барилга, байгууламж	Тээврийн хэрэгсэл	Тоног төхөөрөмж	Тавилга, эд хогшил	Нийт
<i>Өртөг</i>					
2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөр	2,500,587	135,376	1,039,304	307,543	3,982,810
Нэмэгдсэн	-	-	34,934	2,332	37,266
Хасагдсан	(13,361)	-	(139,027)	(20,777)	(173,165)
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр	2,487,226	135,376	935,211	289,098	3,846,911
Нэмэгдсэн	-	-	16,093	-	16,093
Хасагдсан	-	(43,976)	-	-	(43,976)
2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр	2,487,226	91,400	951,304	289,098	3,819,028
<i>Хуримтлагдсан элэгдэл, үгэ цэнийн бууралт</i>					
2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөр	415,296	135,376	922,324	245,722	1,718,718
Тухайн жилийн өөрчлөлт	42,091	-	55,203	18,701	115,995
Данснаас хассан	-	-	(139,027)	(20,777)	(159,804)
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр	457,387	135,376	838,500	243,646	1,674,909
Тухайн жилийн өөрчлөлт	42,091	-	47,542	14,731	104,364
Данснаас хассан	-	(43,976)	-	-	(43,976)
2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр	499,478	91,400	886,042	258,377	1,735,297
<i>Үлдэгдэл ортог</i>					
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр	2,029,839	-	96,711	45,452	2,172,002
2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр	1,987,748	-	65,262	30,721	2,083,731

Элэгдлийн зардлыг Ерөнхий удирдлагын зардалд тусгасан.

## 11 Биет бус хөрөнгө

Мянган төгрөгөөр	Компьютерийн програм хангамж	Тусгай зөвшөөрөл, Дансны тэмдэг	Нийт
<i>Өртөг</i>			
2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөр	7,970,685	-	7,970,685
Нэмэгдсэн	422,673	13,361	436,034
Хасагдсан	(54,367)	-	(54,367)
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр	8,338,991	13,361	8,352,352
Нэмэгдсэн	92,988	-	92,988
Хасагдсан	-	-	-
2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр	8,431,979	13,361	8,445,340
<i>Хуримтлагдсан хорогдуулга</i>			
2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөр	6,698,785	-	6,698,785
Нэмэгдсэн	515,265	-	515,265
Данснаас хасагдсан	(54,367)	-	(54,367)
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр	7,159,683	-	7,159,683
Нэмэгдсэн	632,206	445	632,651
Данснаас хасагдсан	-	-	-
2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр	7,791,889	445	7,792,334
<i>Үлдэгдэл өртөг</i>			
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр	1,179,308	13,361	1,192,669
2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр	640,090	12,916	653,006

Миллениум Ай Ти системтэй холбоотой хорогдуулгын зардлыг Тодруулга 20-д, бусад хорогдуулгын зардлыг Ерөнхий ба удирдлагын зардалд тусгасан.

## 12 Дансны ба бусад өглөг

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Дансны өглөг	1,541,425	1,052,005
Хойшлогдсон орлого	9764	1,136
Цалингийн өглөг	79	35,974
Татварын өглөг	53,699	125,509
	1,604,967	1,214,624

Дансны өглөгт ямар нэгэн хүү тооцохгүй.

## 13 Капитал ба нөөц

### а. Хувьцаат капитал

Мянган төгрөгөөр	Энгийн хувьцаа	Энгийн хувьцаа
	2019	2018
Зөвшөөрөгдсөн хувьцаа (ширхэгээр)	231,305,936	231,305,936
Нэг бүр нь 100 төгрөгийн үнэтэй 231,305,936 энгийн хувьцаа	23,130,594	23,130,594
Тайлант жилд гаргасан болон бүрэн төлсөн	-	-
Нэг бүр нь 100 төгрөгийн үнэтэй 231,305,936 энгийн хувьцаа	23,130,594	23,130,594

Компани нь тогтмол орлогын эрхгүй энгийн хувьцааны нэг ангилалтай.

## 14 Эздийн өмчийн бусад хэсэг

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Барилга*	432,961	432,961
Газар	13,361	13,361
	446,322	446,322

\*Монгол улсын төрийн өмчийн хорооны 2013 оны 340 тоот тогтоолоор "Үнэт цаасны төлбөр тооцооны төвлөрсөн хадгаламжийн төв" ТӨХК-ийн 432,961 мянган төгрөгийн балансын үнэ бүхий 273.71 м.кв ажлын зориулалттай 3 давхрын талбайг "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-д балансаас балансад шилжүүлсэн байна.

## 15 Орлого

2019 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон хугацааны хувьд					
Мянган төгрөгөөр	Зөвлөх үйлчилгээ	Үйлчилгээ	Худалдаа	Бусад	Нийт
Хугацааны тодорхой агшинд хүлээн зөвшөөрсөн орлого	-	1,474,669	-	-	1,474,669
	-	1,474,669	-	-	1,474,669

2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон хугацааны хувьд					
Мянган төгрөгөөр	Зөвлөх үйлчилгээ	Үйлчилгээ	Худалдаа	Бусад	Нийт
Хугацааны тодорхой агшинд хүлээн зөвшөөрсөн орлого	-	1,656,960	-	-	1,656,960
	-	1,656,960	-	-	1,656,960

## 16 Ерөнхий удирдлагын зардал

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон	2018 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон
Цалингийн зардал	868,661	853,483
Элэгдэл, хорогдлын зардал	246,804	141,049
Терминал хураамжийн зардал	21,798	67,190
Ашиглалт, харилцаа холбооны зардал	60,135	56,958
Томилолтын зардал	17,448	36,937
Арга хэмжээ, сургалт ба хандив	33,473	27,275
Мэргэжлийн үйлчилгээний зардал	20,182	20,833
Засвар, үйлчилгээний зардал	21,859	17,583
Бусад зардал	54,305	69,126
	<u>1,344,665</u>	<u>1,290,434</u>

## 17 Милленниум Ай Ти системтэй холбоотой зардал

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон	2018 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон
Засварын зардал	706,835	687,213
Хорогдлын зардал	490,211	490,211
Суутгасан нэмэгдсэн өртгийн албан татвар	70,684	68,721
Сервер үйлчилгээний зардал	27,624	27,624
	<u>1,295,354</u>	<u>1,273,769</u>

Лондонгийн хөрөнгийн биржийн бүтээгдэхүүн болох Милленниум Ай Ти арилжааны системийг 2012 онд нэвтрүүлсэн бөгөөд тасралтгүй үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгааг Тодруулга 2-д дурдсан.

Милленниум Ай Ти системтэй холбоотой өмнөх жилийн зардал

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон	2018 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон
Засварын зардал	-	388,341
Суутгасан нэмэгдсэн өртгийн албан татвар	-	38,834
	<u>-</u>	<u>427,175</u>

2018 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Өргөтгөл Үйлчилгээний гэрээний хугацааг дахин хоёр жилийн хугацаагаар сунгасан. Гэрээний шинэ нөхцлийн дагуу компани нь 2017 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үйлчилгээний төлбөр болох 160,000 ам.доллараар төлөх шаардлагатай болсон. 2018 оны 10 дугаар сард гэрээт үүрэг үүссэний улмаас 2017 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хоорондох үйлчилгээний төлбөр 2018 онд бүртгэсэн байна.

## 18 Санхүүгийн орлого

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон	2018 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон
Бондын хүүгийн орлого	168	168
Банкны үлдэгдлийн хүүгийн орлого	68,916	94,438
	<u>69,084</u>	<u>94,606</u>

## 19 Гадаад валютын ханшийн зөрүүний гарз

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон	2018 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон
Валютын ханшийн зөрүүний олз	7,951	4,279
Валютын ханшийн зөрүүний гарз	(41,100)	(34,585)
	<u>(33,149)</u>	<u>(30,306)</u>

## 20 Орлогын татварын зардал

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон	2018 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон
Тайлант жилийн татвар	6,892	9,444
	<u>6,892</u>	<u>9,444</u>

Үр ашигт татварын хувь хэмжээний нэгтгэл нь дараах байдалтай байна:

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон	Үр ашигт татварын хувь хэмжээ (%)	2018 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон	Үр ашигт татварын хувь хэмжээ (%)
Татварын өмнөх ашиг (СТОУС-ын дагуу)	(1,148,163)		(1,250,401)	
Татварын хувь хэмжээ	10%		10%	
- Тусгай хувь хэмжээгээр татвар ногдуулах орлого	68,916		94,438	
Татвар ногдохгүй орлогын тохируулга:				
- ЗГ-ын бондын хүү	167		167	
<b>Татварын зардал, үүнээс:</b>				
- Тусгай хувь хэмжээгээр ногдуулсан	6,892	10%	9,444	10%

## 21 Санхүүгийн хэрэглүүр

### а. Санхүүгийн хэрэглүүрийн ангилал

Санхүүгийн байдлын тайланд тайлагнасан дансны үнэ нь дараах хөрөнгө, өр төлбөрийн ангилалтай холбоотой:

#### Санхүүгийн хөрөнгө

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Гэрээний хугацаа дуустал эзэмших хөрөнгө оруулалт:		
Бонд	1,000	1,000
Бодит үнэ цэнээр бүртгэж өөрчлөлтийг ашиг алдагдлаар тусгадаг санхүүгийн хөрөнгө:		
Дансны болон бусад авлага	58,360	316,406
Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	953,430	830,386
	<u>1,012,790</u>	<u>1,147,792</u>

#### Санхүүгийн өр төлбөр

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Хорогдуулсан өртгөөр нь хэмжсэн санхүүгийн өр төлбөр		
Дансны болон бусад өглөг	1,604,967	1,214,624
	<u>1,604,967</u>	<u>1,214,624</u>

## 22 Санхүүгийн эрсдэлийн удирдлага

Компани нь санхүүгийн хэрэгслүүдийг ашиглах явцад зарим эрсдэлүүдтэй тулгарч байна. Үүнд зах зээлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл зэрэг байна.

Компани нь арилжааны зорилгоор санхүүгийн хөрөнгийг ч мөн опцион ч худалдаалдаггүй байна. Компанид тулгарч буй томоохон санхүүгийн эрсдэлүүдийг дор харуулав.

### Санхүүгийн эрсдэлийн хүчин зүйлс

#### i. Зах зээлийн эрсдэл

Компани санхүүгийн хэрэгслүүдийг хэрэглэх явцад зах зээлийн эрсдэл, үүнд үндсэн үйл ажиллагаа болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас үүдэн гарах гадаад валют, хүүгийн түвшин болон бусад үнийн эрсдэлтэй тулгардаг байна.

#### Гадаад валютын эрсдэл

Компани нь гадаад валютаар зарим гүйлгээг хийдэг. Иймээс гадаад валютын ханшийн өөрчлөлтийн эрсдэлд өртдөг байна.

Компанийн ихэнх гүйлгээ Монгол төгрөгөөр хийгддэг. Гадаад валютын ханшийн эрсдэлд өртөх нь анх ам.доллараар хийгдсэн Компанийн гадаадад хийсэн борлуулалт, худалдан авалтаас үүдэн бий болдог байна. Мөн Компани нь Англи улсад Миллениум Ай Ти системийн ашиглалтын зардлыг санхүүжүүлэхэд ашигласан ам.долларын өглөгтэй.



Валютын эрсдэлд өртөж буй гадаад валютаар хийгдсэн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг дор харуулав. Доорх дүнг хаалтын ханшаар монгол төгрөг рүү хөрвүүлж удирдлагадаа тайлагнасан байна:

Ам.доллараар	2019 оны 12 дугаар сарын 31-нээрх	2018 оны 12 дугаар сарын 31-нээрх
<i>Санхүүгийн хөрөнгө</i>		
Банкны үлдэгдэл	36,349	257
	<u>36,349</u>	<u>257</u>
<i>Санхүүгийн өр төлбөр</i>		
Дансны өглөг	559,000	1,038,668
	<u>559,000</u>	<u>1,038,668</u>
Цэвэр дүн	<u>(522,651)</u>	<u>(1,038,411)</u>

Ам.долларын эсрэг төгрөгийн 10% (2018: 10%) –ийн өсөлт ба бууралтад үзүүлэх Компанийн мэдрэмжийг доорх хүснэгтээр харуулав. 10% (2018: 10%) нь гадаад валютын ханшийн боломжит өөрчлөлтөд өгөх удирдлагын үнэлгээг харуулдаг. Мэдрэмжийн шинжилгээнд зөвхөн одоогийн гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлс, гадаад валютын ханшийн 10% -ийн (2018: 10%) өөрчлөлт дэх тайлант хугацааны эцэст хийсэн нь хөрвүүлэлтийн тохируулга багтана.

Хэрэв төгрөг ам.долларын эсрэг 10% -аар (2018: 10%) чангарвал, дараах нөлөөг үзүүлэх болно:

Мянган төгрөгөөр	Ам.долларын нөлөө	
	2019	2018
Ашиг, алдагдал	52,265	103,841
	<u>52,265</u>	<u>103,841</u>

Гадаад валютын эрсдэлд өртөх байдал нь тайлант жилд гадаадад хийсэн гүйлгээний хэмжээнээс хамааран зөрүүтэй байна. Гэсэн хэдий ч дээрх шинжилгээ нь валютын эрсдэлд өртөх Компанийн байдлыг харуулж байна.

## 23 Бодит үнэ цэнийн хэмжилт

Компани нь бодит үнэ цэнийг ажиглан зэргээр нь 1-3 түвшинд хуваан бодит үнэ цэнийг анх хүлээн зөвшөөрөхөд ашигладаг санхүүгийн хэрэглүүрийн шинжилгээг хийдэг. Эдгээр түвшин нь:

- Түвшин 1: - Ижил төрлийн хөрөнгө болон өр төлбөрийн идэвхтэй зах зээл дэх зарласан (тохируулаагүй) үнийг ажиглан тодорхойлно;
- Түвшин 2: Хөрөнгө болон өр төлбөрийн хувьд боломжит өгөгдлийг ажиглан шууд (үнэ) болон шууд бусаар (үнээс гаралтай) бодит үнэ цэнийг тодорхойлох аргачлалыг 2-р түвшинд хэрэгжүүлнэ;
- Түвшин 3: Зах зээлийн ашиглаж болох өгөгдөлд тулгуурлахгүйгээр (ашиглагдахгүй өгөгдөл) бодит үнэ цэнийг тодорхойлно. Удирдлага нь санхүүгийн хэрэглүүрийг ангилахдаа бодит үнэ цэнийн түвшинг ашигладаг.

## а. Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн хэмжилт

2018 болон 2019 оны 12 дугаар сарын 31-ний хоорондын давхцалд үндэслэн бодит үнэ цэнийг хэмжсэн санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрүүдийн ангиллын хүрээнд түвшинг доорх хүснэгтээр харуулав:

Мянган төгрөгөөр	2019 оны 12 дугаар сарын 31-нээрх	2018 оны 12 дугаар сарын 31-нээрх
<i>Санхүүгийн хөрөнгө</i>		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	951,622	828,039
Дансны ба бусад авлага	50,019	299,461
Бусад санхүүгийн хөрөнгө	1,000	1,000
	<u>1,002,641</u>	<u>1,128,500</u>
<i>Санхүүгийн өр төлбөр</i>		
Дансны ба бусад өглөг	1,604,967	1,214,624
	<u>1,604,967</u>	<u>1,214,624</u>

*Бодит үнэ цэнийг тодруулах хорогдуулсан өртгөөр нь хэмжсэн санхүүгийн хэрэглүүр*

Гэрээт хугацаа дуусах хүртэл эзэмших хөрөнгө оруулалт нь 16,75 хувийн тогтмол хүүтэй 100 мянган төгрөгийн нэгж үнэтэй 100 ширхэг засгийн газрын бондоос бүрдэнэ. 2020 онд төлөгдөнө.

## 24 Капиталын эрсдэлийн удирдлага

Компани нь цаашид тасралтгүй ажиллах боломжийг хангахын тулд өөрийн хөрөнгөө удирддаг.

Компанийн капиталын бүтэц нь гаргасан капитал, нөөц, хуримтлагдсан ашиг, өр төлбөр зэргийг багтаасан эздийн өмчөөс бүрдэнэ.

Санхүүгийн хараат байдлаас зайлсхийх үр ашигтай санхүүгийн бүтцийг бий болгохын тулд удирдлага Компанийн капиталын шаардлагыг үнэлнэ. Энэ нь өр Компанийн өрийн ангилал бүрийн дэд түвшинг харгалзан авч үздэг.

Компанийн тайлант хугацааны капиталын дүнг доор хураангуйлан харуулав:

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Нийт эздийн өмч	2,182,288	3,337,339
Нэмэх: хоёрдогч зээл	-	-
Хасах: мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	953,430	830,386
Капитал	<u>1,228,858</u>	<u>2,506,953</u>
Нийт эздийн өмч	2,182,284	3,337,339
Зээллэгэ	-	-
Бүх санхүүжилт	<u>2,182,284</u>	<u>3,337,339</u>
Нийт санхүүжилт дэх капиталын харьцаа	<u>56%</u>	<u>75%</u>

## 25 Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс

Мөнгөн гүйлгээг санхүүгийн тайлангийн зорилгоор мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд гар дээрх бэлэн мөнгө, банкны үлдэгдэл, 3 сараас доош хугацаатай богино хугацаат хөрөнгө оруулалт, банкны үлдэгдэл овердрафт зэрэг орно. Мөнгөн урсгалыг тайланд харуулсанчлан тайлант хугацааны эцсээрх мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлийг санхүүгийн тайланд дараах байдлаар нэгтгэн харуулав:

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон	2018 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон
Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	953,430	830,386
	<u>953,430</u>	<u>830,386</u>

## 26 Холбоотой тал

Компанийн холбоотой талуудад толгой компани, охин компани (тусдаа санхүүгийн тайлантай) хараат компани, хамтын хяналт, удирдлагатай аж ахуйн нэгжүүд орно. Үүнд:

- Монгол улсын Засгийн газар
- Төрийн байгууллагууд
- ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлага

### a. Хяналтын харилцаа

Компанийг тус компанийн 100%-ийг эзэмшдэг Сангийн яам хянадаг. Компанийн хяналтын эрх бүхий хамгийн дээд байгууллага нь Монгол улсын Засгийн газар юм.

### b. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ

Тайлант хугацаанд Компани нь дараах ажил гүйлгээг холбоотой талуудтай хийсэн бөгөөд тайлант хугацааны эцсээр дараах үлдэгдэлтэй байна.

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон	2018 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон
<b>Ажил гүйлгээ</b>		

#### Төрийн байгууллагууд

Үйлчилгээ үзүүлсэн	-	21,321
Зээлээс олсон орлого	167	167
Үйлчилгээний худалдан авалт	437,416	228,971
	<u>437,583</u>	<u>250,459</u>

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон	2018 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон
<b>Үлдэгдэл</b>		

#### Монгол улсын Засгийн газар

Олгосон зээл	1,000	1,000
Төрийн байгууллагууд		
Бусад өглөг	53,699	110,166
	<u>53,699</u>	<u>110,166</u>

с. Удирдлага болон тэдний ойр дотны гэр бүлийн гишүүдтэй хийсэн ажил гүйлгээ

Ажилчдын цалингийн тооцооноос харахад удирдлага нь тайлант жил дараах цалинг авсан байна.

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон	2018 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон
Цалин урамшуулал	80,120	73,182
	80,120	73,182

27 Тайлагналын дараах үйл явдал


Тайлангийн өдрөөс хойш материаллаг, тайланд нөлөөлөхүйц үйл явдал гараагүй болно.

28 Орчуулга


Эдгээр санхүүгийн тайланг Монгол, Англи хэл дээр бэлтгэсэн бөгөөд Монгол болон Англи хувилбар хооронд зөрүү гарвал, Монгол хувилбарыг дагах болно.

29 Санхүүгийн тайлангийн баталгаажуулалт

2019 оны 12 дугаар сарын 31-нээр (харьцуулагдах мэдээллийн хэмт) дуусвар болсон санхүүгийн тайланг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр батлав.

  
М.Батхуяг  
ТУЗ-ийн дарга  
Гарын үсэг



  
С.Алтаннамар  
Ерөнхий нягтлан бодогч  
Гарын үсэг